

**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН  
“БОР-ӨНДӨР, АДАГИЙН ДАЛД УУРХАЙ БА БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР”  
ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-000174

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2550466



## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### А. ХАЯГИЙН ХЭСЭГ

1	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
1.	Аж ахуйн нэгжийн нэр	“Монголросцветмет” ТӨҮГ
2.	Улсын бүртгэлийн дугаар	9019029071, регистр 2550466
3.	Үйлдвэрийн нэр	Бор-Өндөр УБҮ
4.	Ордын нэр	Бор-Өндөр, Адаг
5.	ордын байршил	нийслэл/ хот/ аймаг
6.		Хэнтий
		сум/дүүрэг
7.	Ашигт малтмалын төрөл	Хайлуур жонш
8.	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-000174, MV-000173
9.	Ашиглалт эхэлсэн огноо	1981
10.	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/хот
11.		Хэнтий аймаг
12.		Сум/дүүрэг
13.		Бор-Өндөр.
14.		Баг/хороо
15.		Холбоо-1
16.		Гудамж/байр
17.		Үйлдвэрийн район
18.		Шуудангийн хайрцаг
19.		Хэнтий, Бор-Өндөр 213722
20.	Захирлын хаяг	Утас
21.		70567148
22.		Факс
23.		70567 507
24.	Гар утас	
25.	98552017	
26.	Электрон шуудан	
	<a href="mailto:Bor-undur@monros.mn">Bor-undur@monros.mn</a>	
	Вэб хуудас	
	<a href="mailto:Bor-undur@monros.mn">Bor-undur@monros.mn</a>	
24.	ТЭЗҮ хийсэн огноо	
25.	2017	
26.	Ашиглах хугацаа	
	25 жил	
	Жилийн хучин чадал	
	200,0 мян.тн	

## **Б. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

«Бор-Өндөр» УБҮ нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 285 км-т, Өндөрхаан хотоос баруун урагш 180 км-т Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт оршино.

Бор-Өндөрийн орд дээр хүдэр олборлох зөвшөөрлийг хуулийн дагуу MV-000174 (1995.08.18) тоот тусгай зөвшөөрөл авсан. Тус орд газар нь манай улсын томоохон ашигт малтмалын нөөц ба 1982 оноос хайгуул-ашиглалтын үйлдвэрийн журмаар жилд 100,0 мян.тн хүдэр олборлох хүчин чадлаар ажиллаж эхэлсэн.

Баяжуулах үйлдвэрийн эхний ээлжийг жилд 400,0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 1985 онд ашиглалтанд өгсөн ба бүрэн хүчин чадлын (жилд 600,0 мян.тн хүдэр боловсруулах) түвшинд 1990 онд хүрч, олон улсын стандартат тэнцсэн өндөр чанарын хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэж эхэлсэн нь улс орны экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан юм. Хайлуур жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортод гаргах хэмжээгээр УБҮ нь дэлхийн гол үйлдвэрлэгчдийн дотор эхний тавд орж байна.

2009 онд Баяжуулах фабрикт техникийн шинэчлэл хийсэн нь өндөр чанарын хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэлтийн хэмжээг ихээхэн өсгөв.

1982-2017 оны хугацаанд Бор-Өндөр УБҮ-ийн ил ба далд уурхайнуудад (Бор-Өндөр, Адаг, Бор-Хужир, Хөх-Дэл, Бужигар) 9658 мян.тн хүдэр олборлосон байна. Үүнээс гадна УБҮ-т «Монголпросцветмет» ТӨҮГ-ын бусад үйлдвэрүүд Өргөн, Айраг, Бэрх, Хажуу-Улааны уурхайнуудаас мөн хүдэр ирж байв.

1986-2017 оны хооронд УБҮ-ийн Баяжуулах фабрикт 12685,0 мян.тн хүдэр боловсруулсан байна. Энэ хүдрээс 3187,0 мян.тн хайлуур жоншны бүтээгдхүүн гарган авсан байна. Орос, Украян, Япон, АНУ, Солонгос, Энэтхэг болон бусад орнуудын үйлдвэрүүдманай бүтээгдхүүний үндсэн хэрэглэгчид болно.

Өнөөдөр «Бор-Өндөр» УБҮ-ийн бүтцэд:

- Жилд 300,0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай Уулын цех, 200,0 мян.тн-ы хүчин чадалтай Адаг-Хөшөөтийн далд уурхайнууд;
- Жилд 60,0 мян.тн хүдэр олборлох Хөх-Дэлийн ил уурхай
- Жилд 600,0 мян.тн. хүдэр боловсруулж, 150,0 мян.тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай Баяжуулах фабрик;
- Жилд 500,0 мян. тн төмрийн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий Баргилтын ордын төмрийн хүдэр боловсруулах соронзон ангилуурын хэсэг;
- Өндөр чанарын баяжмал үйлдвэрлэх шугам;
- Савлах цех;
- Бүтээгдэхүүн хадгалах агуулахууд;
- Хий шахах станц;
- Эрчим хүчний цех;

- Дулааны станц;
- Төмөр замын цех;
- Автотээврийн цех;
- Төв засвар-механикийн цехүүд орж ажиллаж байна.

УБҮ-ийн ил ба далд уурхайнууд жилд нийт 150 мян.тн хүдэр олборлож байна.

Үйлдвэрийн болон ахуйн бааз нь уурхайчдын Бор-Өндөр хот болно. Тэнд нийгэм соёлын зориулалттай бүх обьектууд байдаг. Уурхайн тосгон, УБҮ нь Орос-Монгол-Хятадын олон улсын төмөр замын зангилаа Айрагийн станцтай төмөр замаар (55 км) холбогдсон байна.

Бор-Өндөрийн УБҮ нь хотожсон үйлдвэр бөгөөд одоо үйлдвэрт 1430 орчим ажилтан ажиллаж байна.

## **В. ТЕХНОЛОГИЙН ТОВЧ ТАЙЛБАР** **Далд уурхайн ажил**

Бор-Өндөрийн ордуудын 2024 оны уулын ажлын төлөвлөгөөг ашиглалтын техник эдийн засгийн үндэслэл, ашиглалтын систем, технологийн дагуу боловсруулан, далд уурхайн аргаар 26,76% агуулагатай 94.0 мянган тонн хүдэр олборлохоор төлөвлөж байгаагаас Бор-Өндөрийн ордын 1,5,6,11,13-р хүдрийн биетүүдээс олборлохоор төлөвлөв.

Бор-Өндөрийн ордын 1 болон 6-р хүдрийн биетүүд дээр 2021 онд үндсэн малталт 536 т.м, 4271 м<sup>3</sup>, бэлтгэл малталт 815 т.м, 5722 м<sup>3</sup>, ашиглалт хайгуулын малталт 52 т.м, 364 м<sup>3</sup>, нийтдээ 1403 туш метр урт, 10357 м<sup>3</sup> уулын цул бүхий нэвтрэлтийн ажил хийгдэхээр төлөвлөгдсөн болно. Мөн Бор-Өндөрийн ордын 1 болон 6-р хүдрийн биетүүд дээр 30 туш метр урт, 126 м<sup>3</sup> уулын цул бүхий огтлол малталт нэвтрэхээр төлөвлөөд байна.

Бор-Өндөрийн ордын далд уурхай нь “**Ашиглалтын**” болон “**Хайгуулын**” гэсэн хүн, ачаа зөөх зориулалттай үндсэн 2 босоо ам ашиглагдаж байна. Ашиглалтын ажил явагдаж байгаа түвшин хоорондын зайд 50м (+1260м, +1210м, +1160м, +1110м) түвшин тутамд хэвтээ малталт квершлагаар хүдрийн биетийг нээн ашиглалт явуулж байна. +1260м-с +1210м, +1060м-с +1045м түвшин хооронд налуу малталтаар нэвтэрч өөрөө явагч ачигч, зөөгч машинуудыг ашиглаж уулын нэвтрэлт болон олборолтын ажлууд явуулж байна. 2020 онд Бор-Өндөрийн ордын 1-р хүдрийн биетэд 1-413-с 1-414 дэд давхаргаар цооногоор нураалтын системээр олборлолтын ажил. 5,6,11,13-р хүдрийн биет дээр +1260 түвшингээс налуу малталт эхлэн бл-11-300, 13-300-г налуу малталт эхлэн 1-р дэд давхарга нээх нэвтрэлтийн ажил, 6-р хүдрийн биет бл-6-500 1110-1060 м, 5-р хүдрийн биет бл-5-500 1060-1045 түвшинд ашиглах ба орчин үеийн бүтээмж өндөртэй өөрөө явагч ачигч зөөгч JCCY2, JKQ-10 маркын машинуудын тусламжтайгаар 6-р хүдрийн биет дээр +1060 түвшингээс налуу малталт эхлэн бл-6-500-аас хүдэр олборлолт болон нэвтрэлтийн ажил хийхээр төлөвлөөд байна.

Бор-Өндөрийн уулын цехийн ажилчдын газрын дээр ажиллагсад ажлын цагийн үргэлжлэх хугацаа 8 цаг, газрын доор ажиллагсад 7 цагын хугацаатай ажиллана. Уурхай нь бүтэн жилийн турш 7 ажлын өдөр, хоногт 3 ээлжээр гулсах горимоор ажилладаг. Далд уурхайн мастер, усчин, өргөх хэсгийн их амны дохиочин, машинч нар 7 ажлын өдөр, хоногт 3 ээлжээр гулсах горимоор ажиллана. Уулын нэвтрэлтийн ажил болон олборлолтын ажилд гарах мөргөцөгийн ажилчид 7 хоногийн ажлын 5 өдөр хоногт 3 ээлжээр гулсах горимоор ажиллахаар төлөвлөж байна.

Ачилт цэвэрлэгээний ажлыг хаман татагч ЛС30, ЛС15, ачигч машин ППН1с-р, шпурын өрөмдлөгийн ажлыг YT28, YT24-р гүйцэтгэнэ. Цооногын өрөмдлөгөд KDX-100A, ЛПС3У маркын өрмүүдийг ашиглан өрөмдөхөөр төлөвлөж байна. Мөн уулын нэвтрэлт болон хүдэр олборолт, тээвэрлэлтийн ажилд өөрөө явагч техникууд БНХАУ-н 2 JCCY2 маркын ачигч, 2 JKQ-10 маркын автосамсволыг, ВГ2,2, ВБР1,6 маркын тэргэнцэр, К10, К7 маркын цахилгаан тэргийг ашиглан төмөр замаар босоо ам руу тээвэрлэн хүргэж, цааш босоо амаар клетээр дээш газрын гадаргад гаргана.

Бор-Өндөрийн далд уурхайн ордын талбайд тархан байрласан хүдрийн биетүүтээс хамаарч “Үлээх” хэлбэрийн агааржуулалтыг сонгож авсан болно. Уулын малталтуудыг агааржуулах агаарыг ажлын түвшинд агааржуулалтын босоо малталтуудаар төв агааржуулах төхөөрөмж ВОД 21-ээр цэвэр агаар өгөгднө. Өгөгдсөн цэвэр агаар квершлаг, штрек, босоо малталтуудаар дамжин нэвтрэлт болон хүдрийн биетүүдийн хүдэр олборлох мөрөгцгүүдэд хүрнэ. Хүдэр нураан олборлох мөрөгцгүүд болон нэвтрэлтийн мөрөгцгүүдэд уурхайн төв агааржуулах төхөөрөмжөөр өгөгдөх цэвэр агаарын хэмжээ дутмаг үед, агааржуулалтыг зөөврийн агааржуулах төхөөрөмжөөр дамжуулан агааржуулалт хийгдэнэ. Агааржуулалтын явцад бохир агаарын урсгал хүдрийн биетүүдийн жигүүрт орших босоо малталтуудаар гадагшлана. Агаарын урсгалын хурд, найрлагыг агааржуулалтын алба, аврах ангитай хамтран байнга шалгаж хяналтанд байлгадаг ба хагас жилд нэг комисс гарган аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу уурхайн агаарын урсгалыг эргүүлж шалгадаг.

### **Өрөмдлөг тэсэлгээний ажил**

#### **a) Өрөмдлөг.**

Бор-Өндөрийн уурхайд Олборлох хүдрийг гүний цооногийг 105-110 диаметртай өрөмддөг. Өрмийн машины марк KDX-100A, ЛПС-3У, БП-100. 1 болон 6-р хүдрийн биет дээр цацраг хэлбэрээр гүний цооногийн өрөмдлөг хийж гүйцэтгэнэ.

Нэвтрэлтийн бэлтгэл малталтуудыг перфораторуудаар өрөмддөг. Перфораторуудын марк нь YT-28 болон хаман татагч (Лебедка) ЛС-17, ЛС-30, мөн уулын цул ачигч ППН-1с, цахилгаан тэрэг KP-7 ашиглаж байна. 5 болон 6-р хүдрийн биетүүдийн блокуудад өөрөө явагч зөөвөрлөгч, тээвэрлэгч JCCY-2м машин, автосамосвот JKQ-10 тоног төхөөрөмжүүдийг хэрэглэж байна. Харин ил уурхайн ажилд цооног өрөмдөгч СБУ-100, перфоратор YT-28 зэрэг төхөөрөмжүүдийг хэрэглэж байгаа бөгөөд цооногийн диаметр 110 мм хүртэл байна.

#### **б) Тэсэлгээний ажил.**

Тэсэлгээний ажлыг “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн дагуу явуулдаг. Бүх малталтуудын өрөмдлөг тэсэлгээний паспортай бөгөөд түүний дагуу тэсэлгээний ажил явагддаг. Уул геологийн болон уулын малталтын онцлогоос хамаарч тэсэлгээний төрөл бүрийн аргыг хэрэглэдэг.

Далд уурхайн тэсэлгээний ажилд эмуульс Ø32, игданит А6 тэсрэх бодис, гол дамжуулах шижим, цочир дамжуулах шижим, СИНВ, бялт, цахилгаан бялт зэрэг хэрэгслүүдийг хэрэглэхээр төлөвлөөд байна. Гол, цахилгаан, хосолсон аргаар нэвтрэлт, олборлолтийн тэсэлгээний ажлыг явуулж байна. 15-20м урттай цооногуудыг цэнэглэгч «Ульба 150» маркын машинаар эммуулин, болон ЭНТБ-р цэнэглэж байна. Шпурыг цэнэглэхдээ бортгон өдөөгчөө гар аргаар саваа модны тусламжтайгаар хийж, энгийн тэсрэх бодисыг КЕРУЛЕН5 маркийн гар хийн буугаар цэнэглэнэ. Тэсэлгээний ажлыг тэсрэх материал, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл, өрөмдлөгө тэсэлгээний ажлын паспорт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу инженер техникийн ажилтны хяналтан доор гүйцэтгэгддэг.

### **Баяжуулалт, боловсруулалтын технологи, уурхайн хаягдлын аж ахуй**

Баяжуулалтын технологи, технологийн схем, ашиглагдах тоног төхөөрөмж, эрдэс авалт, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт.

УБҮ-ийн баяжуулах фабрик 1986 онд Красноярск хотын «Сибцветметнипроект» хүрээлэнгийн төслийн дагуу ашиглалтанд орсон. Төслийн хүдэр боловсруулах хүчин чадал жилд 400 мян.тн, флотацийн баяжмал гаргалт 120 мян.тн байсан.

Өнгөрсөн хугацаанд 2008-2009 онд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, баяжуулах технологийг боловсронгуй болгох, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах чиглэлээр нилээд ажлууд хийгдэж ирсэний үр дүнд жилийн хүдэр боловсруулах хүчин чадал 600 мян.тн, флотацийн баяжмал үйлдвэрлэх хэмжээ 180 мян.тн хүрч ФФ, ФК, ФГ, ФФС маркийн болон бөөнцөглөсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болсон.

Баяжуулах комплекс нь хүдэр ялган бутлах, баяжуулах төв корпус, шүүн хатаах хэсэг, бөөнцөглөх хэсэг, хаягдлын аж ахуй гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Баяжуулах фабрикийн үндсэн үйлдвэрлэлийн барилга, байгууламжууд нь дараах хэсгээс бүрдэнэ:

- хүдрийн чанар дундажлах агуулах
- том бутлалтын корпус хүдэр хүлээн авах бункерийн хамт
- дунд, жижиг бутлалт, хүдэр ялгах төхөөрөмж, гравитацийн корпус
- хүдэр тээвэрлэх конвейруудын галерей
- бүхэллэг бүтээгдэхүүн, хоосон чулуу хадгалах бункер, бутласан хүдрийн бункер, төв корпус, шүүн хатаах хэсэг, насосны болон өтгөрүүлэх хэсгийн барилга, бөөнцөглөх хэсгийн барилга, бэлэн бүтээгдэхүүний агуулах,
- байгалийн дулаанаар хатаах ангарууд
- эргэлтийн усны барилга
- хаягдлын аж ахуй

Хүдэр боловсруулах бүдүүвч нь дараах ажиллагаанаас бүрдэнэ:

- хүдрийн том бутлалт, түүний дараах угаалт
- -130+30мм ангилалын том бутлалтын дараах хүдрийн бүхэллэг баяжмал, хоосон чулуулагаар төрөлжүүлэн гараар ялгах, битүү циклээр дунд ба жижиг бутлуураар хүдрийг -16 мм хүртэл бутлах

Төв корпуст дараах ажиллагаа явагдана:

- хүдэр нунтаглалт;
- хөвүүлэн баяжуулалт;
- завсрын бүтээгдэхүүн болон баяжмалыг өтгөрүүлэх;
- өндөр чанарын баяжмал гаргах;
- урвалж бэлтгэх.

Дараах бүтээгдэхүүн өтгөрүүлэх ажиллагаанд хамрагдана:

- бутлалтаас гарсан анхдагч шлам, үндсэн хөвүүлэлтийн завсрын бүтээгдэхүүн; п
- зэргийн флотацийн баяжмал;
- дутуу баяжуулсан бүтээгдэхүүн; өндөр чанарын баяжмал

Шүүн хатаах хэсэгт дараах ажиллагаанууд явагдана:

- флотацийн бүх төрлийн баяжмал;
- баяжмал хатаалт, тээвэрлэлт, хадгалалт, ачилт;
- хатаах ажиллагаанаас гарсан хийг цэвэрлэх

### **Уурхайн ус таталт ба усан хангамж**

Усны эх үүсвэр, нөөц, чанар:

Дархан сумын ойролцоо газрын доорхи усны орд нь III группт хамаарах ба газрын доорхи гидрогеологийн нөхцөл нь 1983 оны Москва хотын ПИНИИС теслөөр үнэлэхэд илэрсэн нөөцийг тогтоох нь хүндрэлтэй байсан байна. Газрын дор байгаа усны ай сав газруудад I, II, III гэсэн хамгаалалтын бүс тогтоож жил бүр хашилт хамгаалалтуудыг сэргээж засвар үйлчилгээг хийж байна. Дархан сумын усны ай савын цэнгэг усанд ПИНИИС химийн болон бактерлогийн бүрэн шинжилгээг гаргасан байдаг.

Бор-Өндөр УБҮ нь 2019 онд Дархан сумын нутагт “Цээлийн Булаг”-ийн талбайд газрын доорхи усны ашиглалтын хайгууллын ажлыг зохион байгуулж холбогдох төр захиргааны төв байгууллагаар нөөцийг батлуулсан авсан.

Усны барилга байгууламж:

Газрын доорхи усны ордын 4 худагтай, хоёр гүний худаг нөөцөнд байхаар төлөвлөсөн. Тухайн байршилд байгаа нөөц гүний худаг ажлын худаг хоёрын хоорондын зайд 25м, худаг хооронд II, III-р өргөлтийн насост станц, IV цэвэр усны станц, хадгалах нөөц савнуудтай.

Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

Өргөлтийн станцийг ЦНС180/170, худгуудыг ЭЦВ12-100/160 маркийн насосоор тоноглосон асаалтын систем телемеханикийн алсын удирдлагаар хангагдсан. Дарханы газрын доорхи ай савны гүний худгийн хамгийн их бууралтын усны түвшин ашиглалтын явцад 35м, динамик түвшин 25м, Буйлын ай сав дахь гүний худгийн хамгийн их бууралт 35м, харин динамик түвшин 34.0 м, газрын гадаргаас 35-40м гүнд гүний насос суурилагдсан. ПНИИС төсөлд тусгаснаар хоногт 6900м<sup>3</sup>, цагт 287.50 м<sup>3</sup>, 80л/с.

2021 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын “Усны нөөц батлах тухай” А/108 тушаалаар Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дахь “Бор-Өндөр” УБҮ-ийн баяжуулах үйлдвэр, тосгоны унд ахуйн усан хангамжийн зориулалттай “Цээлийн булаг”-ийн газрын доорх усны ордын усны нөөцийг үйлдвэрлэлийн В зэргээр 82л/сек, С зэргээр 8 л/сек, нийт В+С зэргээр 90 л/сек Буюу 7776.0 м<sup>3</sup> гэж тогтоосон.

Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/

Дамжуулах шугам хоолойн урт 45000 м, диаметр нь D-250-300 мм, Ус хангамжийн дамжуулах хоолойг хөрснөөс хамааруулан дунджаар шаварлаг хөрсөнд  $2.7+0.5=3.2$ м, элсэнд  $2.9+0.5=3.4$  м. Хатуу хөрсөнд  $3.8+0.5=4.3$ м. Нийт дамжуулах ган хоолойны гадаргууг битум-резенин бүрхүүлээр тусгаарлаж хийгдсэн. Дамжуулах шугамын худгууд бетонон хийцтэй хийгдсэн ба гидро ударнаас хамгаалагдсан байна.

### Баяжуулах үйлдвэр

Баргилтын төмрийн хүдрийн уурхай нь 2024 онд ил уурхайн ашиглалтаар Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилтын төмрийн ордод нийтдээ 2400 мянган тонн хүдэр олборлож 4080.0 мян м<sup>3</sup> хөрс хуулалтын ажлыг төлөвлөсөн.

Төмрийн хүдрийг авто машинаар дундажлалын овоолгоос баяжуулах фабрикийн хүлээн авах бункер луу зөөж өгнө. Төмрийн хүдэр бэлтгэх соронзон ялгагчийн бүдүүвч жоншны хүдэр бэлтгэх, бутлах, нунтаглах техникийн бүдүүвч хоорондоо ижилхэн.


Бутлах хэсэгт бутлалтын II үе шатны туузан конверийн дараа хуурай соронзон ялгагч тусгайлан байрлуулсан. Хуурай соронзон ялгагч нь дамран соронзон ялгагч СТ-811 соронзон хүчдэлийн талбайн 2800 GS. Хуурай соронзон ялгагчийн хоосон чулуулаг нь туузан дамжуулагчаар дамжин шигшүүрт орж бүхэллэгийн хэмжээгээр 2 хэсэгт ангиллагдан хөвүүлэн баяжуулалтын хадгалах бункерт хураагдана. Хуурай ялгагч нь соронзлогдсон бүтээгдэхүүн ГИТ -52M нойтон шигшүүрт орно. Энэ шигшүүрт бүтээгдхүүн -8+0мм , -16+8мм , -70+1 бмм-ээр 3 ангилагдана . -8+0мм жижиг хэсэг KCH-20 буюу мушкиа ангилагчид орно. -16+18мм дунд хэсэг №5 туузан дамжуулагчаар зөөгдөж буталсан хүдрийн бункерт орно. -70+1 бмм болох том хэсэгбутлалтын III үе шат болох конусан бутлуур КМД -1750T орно. КМД-1750T бутлагчаас гарсан бутлагдсан хүдэр №2 туузан дамжуургаар зөөгдөнө.



Буталсан хүдрийн бункерээс хүдрийг нунтаглалтын I үе шат МШР -3.2\*3.1 бөмбөглөгт тээрэмд 2-KCH-24 мушкигаа ангилагчид оруулаад битүү давтамжтайгаар

ажиллууна. 2-KCH-24 мушкиа ангилагчаас гарсан халиаг нойтон соронзон ялгагч I үе шат хагас эсэргүүцэлтэй соронзон ялгагч СТВ-1030 оруулна. СТВ-1030-ын хаягдалыг шахуургаар шахаж хяналтын ялтсан соронзон ялгагч Ф-800ЧЮ өгнө. СТВ-1030-ын баяжмалыг шахуургаар шахаж ГЦР-360 төвөөс зугтах хүчний ангилагчид өгнө. ГЦР-360-ын элсийг нунтаглалтын II үе шат тээрэмд МШР 3,2\*3.1 оруулна. Өөрийн урсгалаар ирэх халиаг нойтон соронзон баяжмал II үе шатны нэгдүгээр ялгагч СТВ-1024 хүлээн авна. СТВ-102 нэгдүгээр ялгагчийн баяжмал цэвэрлэгэний хоёрдуугаар ялгагч СТВ-1024 рүү орно. Нэгдүгээр, хоёрдуугаар СТВ-1024 соронзон ялгагчийн хаягдалыг хяналтын соронзон ялтаст ялгагч Ф-900410-д хүлээн авна. Ялтсан соронзон ялгагчийн хаягдал нь төв хэсгийн хаягдал руу хаягдалын шахуурганы зумпфэнд өөрийн урсгалаар өгөгддөг. Төв хэсгийн хаягдал завсарийн бүтээгдэхүүн өтгөрүүлэгчийн халиа 2 нийлээд шахуургаар шахагдаж баяжуулалтын фабрикийн Хаягдлын аж ахуйд (ХАА) очино.

Хоёрдуугаар СТВ-1024 соронзон ялгагчийн баяжмал өөрийн урсгалаар баяжмал өтгөрүүлэгч Ц-25 орно. Өтгөрсөн баяжмал Ц-25 өтгөрүүлэгч шахуургаар шахагдан шүүрүүлэлтийн хэсэгт битүү шүүлтүүр ДО-50Ч2,5 №1, 2, 4-т өгөгдөнө. Битүү шүүрүүлэлтийн № , 2 шүүгдсэн баяжмал туузан дамжуулагчаар зөөгдөж биг бэги шуудайнд савлагдана. Битүү шүүгч № 4 шүүгдсэн баяжмал чийглэг нь 10-12% учир №4 хатаагч барабанаар дамжин хатаагдаад баяжмал бигэ бэгинд савлагдана. Савлагдсан төмрийн баяжмалаа задгай талбай дээр сэрээт ачигчаар зөөж байрлуулна. Талбайгаас шуудуутай төмрийн баяжмалаа задгай вагонд ямаан (кран ) өргөгчөөр ачиж төмөр замын пүүгээр пүүлээд захиалсан хэрэглэгч рүү явуулна.

## “Бор-Өндөр” УБҮ-ийн баяжуулах фабрикийн тоног төхөөрөмжийн схем





**“Бор-Өндөр” УБҮ-ийн Баяжуулах фабрикийн тоног төхөөрөмж**

№ д/ д	Тоног төхөөрөмжийн нэр			Техникийн үзүүлэлт			Тоног төхөөрөмжийн насжилт			Цахилгааны зарцуулалт		Үнэ, сая.төг	
	Төрөл	Марк	Үйлдвэр-лэсэн улс	Хэмжих нэгж	Хүчин чадал	Тоо ширхэг	Үйлдвэр-лэсэн он	Ашиглал -танд өгсөн он	Ашиглалтын хугацаа	Хэмжих нэгж	Хэрэгцээ т хүчин 4адал	Анхны үнэ	Үлдэгдэл үнэ
1	Бутлуур	ЩДП 0,9*1,2	ОХУ	M <sup>3</sup> /ц	160	1	1985	1986	30	kВт*ч	100	547,5	292,8
2	Бутлуур	КСД 1750Гр	ОХУ	M <sup>3</sup> /ц	160-300	1	1985	1986	30	kВт*ч	160	1,1	0
3	Бутлуур	КМД 1750Т	ОХУ	M <sup>3</sup> /ц	80-100	1	1985	1986	30	kВт*ч	160	1,1	0
4	Тэжээгч	1-15-60	ОХУ	M7ц	160	1	1985	1986	30	kВт*ч	22,7	0,5	0
5	Шигшүүр	ГИТ-42М	ОХУ	т/ц	970	1	2012	2012	2	kВт*ч	15	50,7	40,1
6	Шигшүүр	ГИТ-52М	ОХУ	т/ц	1235	1	2012	2012	2	kВт*ч	18,8	74,4	59,5
7	Ангилан ялгагч	К-14	ОХУ	M7ц	100	1	1985	1986	30	kВт*ч	75	0,7	0
8	Ангилан ялгагч	KCH-20	ОХУ	т/ц	230	1	1994	1994	20	kВт*ч	13	6,56	0
9	Туузан дамжуулга №1	ЛК	ОХУ	т/ц	150	1	1986	1986	30	kВт*ч	45	0,153	0
10	Туузан дамжуулга №2	ЛК	ОХУ	т/ц	280	1	1986	1986	30	kВт*ч	40	0,92	0
11	Туузан дамжуулга №3	ЛК	ОХУ	т/ц	280	1	1986	1986	30	kВт*ч	11	0,004	0
12	Туузан дамжуулга №4	ЛК	ОХУ	т/ц	280	1	1986	1986	30	kВт*ч	40	0,099	0
13	Туузан дамжуулга №5	ЛК	ОХУ	тц	120	1	1986	1986	30	kВт*ч	37	0,067	0
14	Туузан дамжуулга №6	ЛК	ОХУ	т/ц	100	1	1986	1986	30	kВт*ч	18,5	0,017	0
15	Туузан дамжуулга №7	ЛК	ОХУ	т/ц	100	1	1986	1986	30	kВт*ч	18,5	0,017	0
16	Туузан дамжуулга №10	ЛК	ОХУ	т/ц	80	1	1992	1992	22	kВт*ч	5,5	0,054	0,04

17	Туузан дамжуулга №11	лк	ОХУ	т/ц	80	<sup>1</sup>	1992	1992	22	кВт*ч	5,5	0,054	0,04
18	Туузан дамжуурга №11 <sup>a</sup>	лк	ОХУ	т/ц	SU	<sup>1</sup>	2002	2002	12	кВт*ч	11	0,054	0,04
19	Туузан дамжуурга №12	лк	ОХУ	т/ц	100	<sup>1</sup>	1992	1992	22	кВт*ч	15	0,054	0,04
20	Туузан дамжуурга №12 <sup>o</sup>	лк	ОХУ	т/ц	80	<sup>1</sup>	2002	2002	12	кВт*ч	5,5	0,075	0,05
21	Туузан дамжуурга №13	лк	ОХУ	т/ц	60	<sup>1</sup>	1992	1992	22	кВт*ч	7,5	0,075	0,05
22	Туузан дамжуурга №2 <sup>a</sup>	лк	ОХУ	т/ц	40	<sup>1</sup>	2004	2004	10	кВт*ч	11	0,054	0,04
23	Туузан дамжуурга №1(ФСО)	ЛК	ОХУ	т/ц	40	1	1998	1998	16	кВт*ч	7,5	0,175	0,1
24	Туузан дамжуурга №2(ФСО)	ЛК	ОХУ	т/ц	40	1	1998	1998	16	кВт*ч	7,5	0,175	0,1
25	Туузан дамжуурга №3(ФСО)	ЛК	ОХУ	т/ц	80	1	1998	1998	16	кВт*ч	15	0,275	0,18
26	Тээрэм	МШР3,2*3,1	ОХУ	м	d-3,2; 1-3,1	2	1985	1986	30	кВт*ч	1260	85,74	0
27	Тээрэм	МШР3,2*3,1	ОХУ	м	d-3,2; 1-3,2	1	1994	1995	20	кВт*ч	630	154,3	0
28	Тээрэм	МШР2,1*2,2	ОХУ	м	d-2,1;1-2,2	1	1986	1987	30	кВт*ч	200	2,94	0
29	Ангилуур	2-КСН-24	ОХУ	м т/ц	d-2,4 585	1	1985	1986	30	кВт*ч	40	0,324	0
30	Баяжуулагч	РИФ-25	ОХУ	м <sup>3</sup> /мин	30	3	2009	2009	5	кВт*ч	332	2004	1054,2
31	Баяжуулагч	РИФ-8,5	ОХУ	м <sup>3</sup> /мин	10	5	2009	2009	5	кВт*ч	680	2104	803,4
32	Баяжуулагч	РИФ-3,5	ОХУ	м <sup>3</sup> /мин	2	2	2009	2009	5	кВт*ч	105	617	324,3
33	Тэжээх төхөөрөмж	пл	ОХУ	т/ц; мм	150; 1200	1	1985	1986	30	кВт*ч	44	6,33	0
34	Вакуум шүүгч	ДО 50*2,5	ОХУ	S-m2 ; D-М	50;2,5	4	1985	1986	30	кВт*ч	44,8	0,37	0
35	Өтгөруулэгч	Ц-25	ОХУ	м	25	3	1985	1986	30	кВт*ч	19,2	3,3	0
36	Хатаах зуух	БН-14*2,8	ОХУ	D-м; L-м	2,8;14	4	1985	1986	30	кВт*ч	360	0,16	0
37	Элсний насос	БВЛ-800/40	Украин	м	800	1	2009	2010	4	кВт*ч	212	424,4	337,3
38	Урвалж хуваарьлагч	АСПДР	Дани	л/ц	5125	1	2009	2009	5	кВт*ч	4,8	460,1	402,1

39	Гидроциклон	АНГЦЦ-ГЦ	ОХУ	ш	12	1	2009	2009	5	кВт*ч	220	667,3	630,7
40	Автоклав		Хятад	M <sup>1</sup>	3,2	2	2012	2012	2	кВт*ч	15	15,2	15,1
41	Насос	6/4D-AHH	Австралия	м <sup>3</sup> /ц	160	2	2009	2009	5	кВт*ч	30	95,6	95,2
42	Hacoc	8/6E-AHH	Австралия	м /ц	313	4	2009	2009	5	кВт*ч	220	290,7	280,1
43	Hacoc	8/6E-AH-GL	Австралия	м <sup>3</sup> Ai	271	2	2009	2009	5	кВт*ч	74	118,6	110,2
44	Hacoc	65V-GPS	Австралия	м /ц	29	8	2011	2011	3	кВт*ч	44	34	18

**“Бор-Өндөр” УБҮ-ийн Бор-Өндөрийн далд уурхайн ашиглалтын техник, тоног төхөөрөмжийн жагсаалт**

№ д/д	Тоног төхөөрөмжийн нэр				Хүчин чадал багтаамж		Үнэ, сая.төг		Өмчлигийн хэлбэр	Ашиглалтын хугацаа			Цахилгааны зарцуулалт		Түлш зарцуулалт			Техникийн бэлэн байдлын тээвэр	ТЭЗҮ-Д тусгайдсан зарчмын
	Марк	Терөл	Завар	Үйлдвэрлэсэний улс	Нэгж	Хэмжээ	Анхны үнэ	Үлдэгдэл үнэ		Үйлдвэрлэсэний он	Ашиглалтанд өгсөн он	Ашиглалтын хугацаа, жил	Хэмжих нэлж (квт.час)	Сууринтэсний хувчин	Хэмжих нэлж (л/мот.цаг)	Нийт ажилзах мот.цаг	Нийт зардуулж түвшний хэмжээ		
1	ЛПС-3У	Суурин өрмийн төхөөрөмж	цооног өрөмдөх	ОХУ	мм/м	155/50	3,160357	0	Терийн өмч	2002	2003	10	-	-	-	-	-	дунд	тийм
2	ЛПС-3У	Суурин өрмийн төхөөрөмж	цооног өрөмдөх	ОХУ	мм/м	155/50	3,160357	0	Терийн өмч	2002	2003	10	-	-	-	-	-	дунд	тийм
3	ППН-1С	Хийн ачигч машин	төмөр зам	ОХУ	м3/мин	1,25	63,93418	53,5030912	Терийн өмч	2010	2011	10	-	-	-	-	-	муу	тийм
4	ППН-1С	Хийн ачигч машин	төмөр зам	ОХУ	м3/мин	1,25	68,05173	26,9670649	Терийн өмч	2008	2008	10	-	-	-	-	-	муу	тийм
5	ППН-1С	Хийн ачигч машин	төмөр зам	ОХУ	м3/мин	1,25	61,12283	22,4097417	Терийн өмч	2008	2008	10	-	-	-	-	-	муу	тийм
6	ППН-1С	Хийн ачигч машин	төмөр зам	ОХУ	м3/мин	1,25	38,93068	8,37604969	Терийн өмч	2006	2007	10	-	-	-	-	-	муу	тийм
7	ППН-1С	Хийн ачигч машин	төмөр зам	ОХУ	м3/мин	1,25	38,93068	8,37604969	Терийн өмч	2006	2007	10	-	-	-	-	-	муу	тийм
8	7- КР-М	Элекровоз	төмөр зам	ОХУ	тн	7	178,9268	35,7627796	Терийн өмч	2005	2007	10	кВт.цаг	66	-	-	-	дунд	тийм
9	7- КР-М	Элекровоз	төмөр зам	ОХУ	тн	7	153,9515	15,3754594	Терийн өмч	2005	2007	10	кВт.цаг	66	-	-	-	дунд	тийм
10	7KPM1	Электровоз	төмөр зам	ОХУ	тн	7	173,1172	116,627789	Терийн өмч	2011	2011	10	кВт.цаг	66	-	-	-	дунд	тийм
11	JCCY-2	Ачигч машин	Дугуйт ачигч	БНХАУ	м3	2	197,5028	116,836467	Терийн өмч	2010	2010	10	-	-	9,5л/мот. цаг	1467	13941	муу	тийм
12	JCCY-2	Ачигч машин	Дугуйт ачигч	БНХАУ	м3	2	217,2597	103,216218	Терийн өмч	2009	2009	10	-	-	9,5л/мот. цаг	453	4303	дунд	тийм
13	JKQ-10	Автосамосвал	Дугуйт	БНХАУ	тн	10	255,4081	140,463984	Терийн өмч	2010	2010	10	-	-	9,5л/умот. цаг	590	5603	муу	тийм
14	JK.Q-10	Автосамосвал	Дугуйт	БНХАУ	тн	10	255,4081	140,463984	Торийн өмч	2010	2010	10	-	-	9,5л/мот. цаг	1910	18152	дунд	тийм
15	CAT-980P	Погрузчик	Дугуйт ачигч	АНУ	3 м	5	536,4216	130,00976	Терийн өмч	2007	2007	20	-	-	28,6л/мот. цаг	4118	117786	сайп	тийм
16	CAT-980F	Погрузчик	Дугуйт ачигч	АНУ	3 м	3,8	226,2581	56,48193	Терийн өмч	1994	1994	20	-	-	28,6л/мот. цаг	1663	47568	дунд	тийм
17	LW-540F	Погрузчик	Дугуйт ачигч	Хятад	3 м	3	43,0542	1,1106	Терийн өмч	2004	2004	10	-	-	15л/мот. 1Ш1	1663	24615	муу	тийм
18	SL-50W №1	Погрузчик	Дмлйт ачигч	Хятад	3 м	3	60,5133	42,5565	Терийн өмч	2010	2010	10	-	-	15л/мот. цаг	3802	58758	дунд	тийм
19	SL-50W №2	Погрузчик	Дмуйт ачигч	Хятад	3 м	3	97,2401	95,9624	Терийн өмч	2014	2014	10	-	-	15л/мот. цаг	2402	36122	сайн	тийм

20	T-170	Бульдозер	Өрөө явагч	ОХУ	м.х	170	27,0525	0	Төрийн өмч	1993	1994	20	-	-	8,4л/мот цаг	882	7409	муу	тийм
21	ТЭМ12- 72	Тепловоз	Өрөө явагч	ОХУ	л.с	1200	999,6922	683,5469	Төрийн өмч	1986	1986	20	-	-	16,7л/мот цаг	2246	37515	сайи	тийм
22	Комацу	Өөрөө буулгагч	HD325	Япон	тн	32,5	318,402	86,3265831	Төрийн өмч	1998	1998	16	-	-	130л/ 100 км	3000	70056	дунд	тийм
23	Комацу	Өөрөө буулгагч	HD325	Япон	тн	32,5	205,958	4,13364852	Төрийн өмч	1998	1998	16	-	-	130л/ 100 км	3000	70056	дунд	тийм
24	БелАЗ	Өөрөө буулгагч	7540	Беларусь	тн	30	170,5761	63,6728664	Төрийн өмч	2008	2008	6	-	-	142.4л/ ЮОкм	3000	125000	дунд	тийм
25	БелАЗ	Өөрөө буулгагч	7540	Беларусь	тн	30	142,5197	17,4643893	Төрийн өмч	2005	2005	9	-	-	142.4л/ ЮОкм	3000	125000	дунд	тийм
26	БелАЗ	Өөрөө буулгагч	7540	Беларусь	тн	30	213,9142	95,3737844	Төрийн өмч	2008	2009	5	-	-	142.4л/ ЮОкм	3000	125000	дунд	тийм
27	БелАЗ	Өөрөө буулгагч	7522	Беларусь	тн	27	170,9675	84,3272803	Төрийн өмч	2008	2009	5	-	-	142.4л/ ЮОкм	3000	125000	дунд	тийм
28	ХОВО	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	48,40166	16,5596499	Төрийн өмч	2007	2008	6	-	-	38л/ ЮОкм	4320	68000	дунд	тийм
29	ХОВО	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	48,40166	16,5728998	Төрийн өмч	2007	2008	6	-	-	38л/ ЮОкм	4320	68000	дунд	тийм
30	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	48,40166	16,5596499	Төрийн өмч	2007	2008	6	-	-	38л/ ЮОкм	4320	68000	дунд	тийм
31	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	53,54663	18,7366644	Төрийн өмч	2007	2008	6	-	-	38л/ ЮОкм	4320	68000	дунд	тийм
32	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	53,54663	18,7366644	Төрийн өмч	2007	2008	6	-	-	38л/ ЮОкм	4320	68000	дунд	тийм
33	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	55,04663	16,3366473	Төрийн өмч	2007	2008	6	-	-	38л/ ЮОкм	4320	68000	дунд	тийм
34	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	53,54663	18,736662	Төрийн өмч	2007	2008	6	-	-	38л/ ЮОкм	4320	68000	дунд	тийм
35	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	62,27028	43,0079161	Төрийн өмч	2011	2011	3	-	-	38л/ 100 км	4320	68000	сайн	тийм
36	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	62,27028	43,0079161	Төрийн өмч	2011	2011	3	-	-	38л/ 100 км	4320	68000	сайн	тийм
37	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	62,27028	43,0079161	Төрийн өмч	2011	2011	3	-	-	38л/ 100 км	4320	68000	сайн	тийм
38	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	62,27028	43,0079161	Төрийн өмч	2011	2011	3	-	-	38л/ ЮОкм	4320	68000	сайн	тийм
39	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	62,27028	43,0079161	Төрийн өмч	2011	2011	3	-	-	38л/ 100 км	4320	68000	сайн	тийм
40	ХОВО	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	62,27028	43,0079161	Төрийн өмч	2011	2011	3	-	-	38л/ ЮОкм	4320	68000	сайн	тийм
41	ХОВО	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	62,27028	43,0079161	Төрийн өмч	2011	2011	3	-	-	38л/ ЮОкм	4320	68000	сайн	тийм
42	хово	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	67,05026	55,3366637	Төрийн өмч	2012	2012	2	-	-	38л/ ЮОкм	4320	68000	сайн	тийм
43	ХОВО	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	67,05026	55,3366637	Төрийн өмч	2012	2012	2	-	-	38л/ ЮОкм	4320	68000	сайн	тийм

44	ХОВО	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	67,05026	55,3366637	Төрийн өмч	2012	2012	2	-	-	38л/ ЮОкм	4320	68000	сайн	тийм
45	ХОВО	Өөрөө буулгагч	3257	Хятад	тн	20	67,05026	55,3366637	Төрийн өмч	2012	2012	2	-	-	38л/ ЮОкм	4320	68000	сайн	тийм
46	КамАЗ- 53512	Автокран	KC-55713- 1К	ОХУ	тн	25	137,8466	36,8930786	Төрийн өмч	2007	2007	7	-	-	47л/ ЮОкм,	2112	11280	дунд	тийм
47	КрАЗ-256	Автокран	KC-4561A	ОХУ	тн	17	1,130435	0,04368485	Төрийн омч	1984	1990	24	-	-	59л/ ЮОкм,	2112	14160	дунд	тийм
48	Зил-130	Автовышка	АГП-22	ОХУ	КГ	300	16,11282	0	Төрийн өмч	2003	2003	11	-	-	40,2л/ ЮОкм,	2112	10353	дунд	тийм
49	Зил-130	ТМ тээвэрэлч	ачааны	ОХУ	тн	5	48,5	36,64	Төрийн өмч	2007	2007	7	-	-	40,2л/ ЮОкм,	3600	45000	сайн	тийм

## **2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

### **Голлох сөрөг нөлөөлөл**

#### **I. Хөрсний элэгдэл-эвдрэл бохирдол**

Бор-Өндөр, Адагийн хайлуур жоншны бүлэг ордод хүдрийн биетийн байршил, орших гүн, ордын төрөл, нөөцийн хэмжээ зэргээс хамаарч ил ба далд аргыг хослуулах замаар олборлолт явуулж ирсэн.

Хөрс хуулалт уурхайн малталтаар газрын хэвлэлийд томоохон орон зайд үүсэхийн сацуу ойр орчмын харьцангуй тэгшхэн газруудад үржил шимт хөрс, хурдас чулуулгийн овоолгууд байгуулж, хүдэр тээвэрлэлтээр хөрс зурvasлан ургамалгүй болж нүцгэрэн элэгдэж эвдэрсэн. Цаашлаад уурхай үйлдвэрийн ажлын бүсэд ачиж буулгах, ялгах зэрэг үйл ажиллагаанд хөрс дундаас хүчтэй эвдрэлд орсон байна.

2008-2015 онд уурхайн малталт, овоолго байгуулах, уурхайн ашиглалтаар эвдрэлд орсон талбайн нийт хэмжээ Бор-Өндөрийн ордод 268,98 га, Адагийн ордод 74,91 га байна. Энд хатуу хог хаягдлаар бохирдсон, хаягдлын сан дор орсон талбай, тоосонд дундаас хүчтэй өртсөн талбайг хамааруулж авч үзээгүй болно.

Хаягдлын сангийн зүүн талаар далангийн биртүүдийг өндөрлөх ажил хийгдээгүй олон жил болж байгаа нь элс хийсч хунгарласаар даланг давж овоорсон, сангийн хуурай гадаргуугаас хийсэх элс салхины зонхилох чиглэл дагуу зүүн урагш хамгийн их талбайд хийсэн тархахын зэрэгцээ сангийн өмнө талын ухааг даван дэнж дэвсэг дээгүүр хөрс жигд зузаантайгаар элсээр хучигдсан байна. Хаягдлын сангийн талбайн төв хэсгийг эс тооцвоос өмнө, зүүн болон баруун хэсэгт булинга хатаж хуурайшсанаас тоосны томоохон эх үүсвэр болсоор байна.

Хаягдлын санд 148,07 га талбай хамрагдахаас гадна хаягдлын сангаас хийсэх тоосонцор элсэнд янз бүрийн зузаантайгаар дарагдсан, хучигдсан, бүрхэгдсэн талбайн хэмжээ 1956,5 га байна.

Бор-Өндөр УБҮ нь 2020 онд хаягдлын даланг сайжруулан өндөрлөх ажлыг гүйцэтгэсэн. Иймд ирэх онуудад элс хийсч хунгарлах даланг давах зэрэг эрсдэл үүсэхгүй байх үүднээс тус талбайн салхин дээд талд нь мод тарих ажлыг ирэх оноос эрчимжүүлэхээр төлөвлөж байна. Одоогоор нийт 15000 ширхэг мод тарьсан.

#### **Дүгнэлт:**

Бор-Өндөрийн уурхай орчмын хөрсний дээжид хийсэн лаборторийн шинжилгээний дүнгээс үзэхэд хортой химийн элементүүд болох хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), никель (Ni), цайрын (Zn) агуулга нь энэ хавь газарт нийтлэг элсэнцэр ширхэгийн бүрэлдэхүүнтэй хөрсний Үндэсний стандартын (MNS 5850:2008) зөвшөөрөгдхөн агууламжийн хэмжээнд хүрээгүй, бага тоон үзүүлэлтээр илэрч байгаа нь эдгээр органик биш бохирдуулагч элемэнтээр хөрс бохирдоогүй болохыг харуулж байна.

Харин УБҮ-ийн хашаан доторх бохирдсон хөрсний зарим дээжинд хийсэн шинжилгээний дүнгээс үзвэл хүлцэх хэмжээнээс хар тугалга 2,3 дахин, кадмий 1,4 дахин их бохирдолтой гарч байна.

Хаягдлын сангийн урдуур үргэлжлэх ухаагийн орой буюу дэнж дэвсэг газраар тогтвортсон сайргархаг элсэнцэр хүрэн хөрсний гадарга дээр усан сангийн захаас хийсч тогтсон хучаас элсэн дахь хар тугалга (55,3-57,7 мг/кг), кадмийн агуулга (1,01 мг/кг) буюу хүлцэх агууламжаас бага зэрэг давсан тоон үзүүлэлттэй байгаа нь уурхайн хаягдлын санд тунасан тоосонцор элсээр хөрс бохирдож эхэлж байгаагийн илрэл болно.

## II. Агаарын бохирдол

Уулын баяжуулах үйлдвэр, одоо ашиглалт явуулж байгаа далд уурхайн ашиглалтаас агаарт хамгийн их нөлөөлөл үзүүлж байгаа объект бол тунгаан цэвэршүүлэх замаар эргэлтээр ашиглаж байгаа хаягдлын санд нийлүүлж буй технологийн шингэн хаягдал болно.

Хаягдлын сангийн гадаргуу байнгын чийгтэй байх боломжгүйгээс тэнд хуримтландаан лаг шавар хатаж, тоосонцор элс хийсэн тархах эх үүсвэр болсоор олон арван жил болж байна. Хаягдлын сангийн талбайн тоос босох хуурай хэсгийн талбай жил жилээр улам бүр нэмэгдэн нарийн ширхэгтэй элс шороо салхины зонхилор чиглэл дагуу зүүн, зүүн урагш, урагш хийссээр нутгийн малын бэлчээрт үүсмэл цөлжилтийг бий болгоод байна.

Бор-Өндөр УБҮ нь 2023 онд Дулааны станц, Баяжуулах фабрик цехүүдэд тус бүрд нь БОНБНҮ хийлгэж сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### Дүгнэлт:

Тоосны агууламж тодорхойлох хэмжилтийг УБҮ-ийн хамгийн тоостой цех дамжлагууд, үйлдвэрийн гадаа ажлын бүс, хүдэр тээвэрлэлтийн зам, далд уурхай, үйлдвэрийн хаягдлын сан, вагон буулгах ачих талбай зэрэг нийт 12 цэгт хийсэн.

УБҮ-ийн том, дунд, бага бутлуурын оролт, гаралт дээр 2,07-54,8 мг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх хэмжээнээс 20,7-548,8 дахин их байна.

Үйлдвэрийн харьцангуй бага тоосны бохирдолттой гэж хэлж болох баяжуулах болон үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн савлах цех хэсгүүд дээр тоосны агууламж 0,488-0,798 мг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх хэмжээнээс 4,9-8,0 дахин их байна. Иймээс УБҮ-ийн үндсэн цех дамжлагууд нийтдээ тоосны бохирдолттой гэж хэлж болно.

УБҮ-ийн хаягдлын сан орчимд салхи тогтуун үед хийсэн хэмжилтээс харвал тоосны агууламж 0,461 мг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх хэмжээнээс 4,6 дахин их байна. Хаягдлын сан бол тоосны томоохон эх үүсвэрийн хувьд байнгын тоосролттой төдийгүй, тоосны хөрсөн буух, тархалтын зон жилээс жилд тэлсээр байна.

## III. Гадаргын ба газрын доорх ус

### Гадаргын ус

Адаг, Бор-Өндөрийн хайлуур жоншны орд орчмын талбай нь Төв азийн гадагш урсацгүй ай савд хамаараах бөгөөд Хэнтийн нурууны салбар уулс Сүмбэр, Чойрын богд, Сансар уулсын усны хагалбараар зааглагдана. Бор-Өндөрт 1982, Адагт 1987 оноос хойш 30-аад жилд хайлуур жоншны олборлох үйл ажиллагаа явагдаж байна. Энэ бүс нутаг гадаргын байнгын урсацгүй, хуурай хээрийн бүсэд хамаарна. Өвөл хуримтлагдсан цас

хайлах, зуны аадар бороо орох үеэр олон тооны хуурай сайраар түр зуурын үер ажиглагдана.

Адагийн уурхай нь уул, толгодийн оройд байрлах учир хур борооны үерт автхаарагүй юм. Харин Адагийн ордыг дахин ашиглавал ашиглах явцад гарч байгаа тоос шороо Бор-Өндөрийн УБҮ-ийн чиглэлд салхины урсгалаар туугдан хөрс, агаарыг бохирдуулж сумын төвийн оршин суугчид болон орчны экологийн байдалд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Бор-Өндөрийн баяжуулах үйлдвэр өөрийн хүч хөрөнгөөр сайрын гулдрилыг нийтэд нь хаасан шороон далан хийж, борооны үерийн усыг үйлдвэрлэл явуулж байгаа талбайгаас зайлцуулах гидротехникийн арга хэмжээ авсан байdag.

### Газрын доорх ус

